

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 дугаар сарын 15

Дугаар 60

Улаанбаатар хот

“Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн
одонд уламжлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонгоор шагнуулахаар тодорхойлсон эхчүүдийн нэрсийг нэгдүгээр, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулахаар тодорхойлсон эхчүүдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.“Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулахаар тодорхойлж буй эхчүүдийн материалыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлэх, тогтоолын хэрэгжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга (И.Баттөгс)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР